



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 4/216

Мандалговь

┌ Өвсний нөөц бүрдүүлэх тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3 “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Засгийн газрын 2020 оны 19 тоот тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд зуншлага тааруу байснаас 2020-2021 оны өвөл, хаваржилт хүндэрч болзошгүй байдал үүссэн, зах зээл дээрх өвсний нийлүүлэлт хомс байгаа зэрэг онцгой нөхцөл байдал, зайлшгүй хэрэгцээ шаардлагыг харгалзан хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор 40 тонн өвсний нөөцийг бүрдүүлсүгэй.

2. Нөөц бүрдүүлэхэд шаардагдах 26,000,000 /Хорин зургаан сая/ төгрөгийг Мал хамгаалах сангаас зарцуулахыг нягтлан бодогч О.Бямбасүрэнд зөвшөөрсүгэй.

3. Холбогдох стандартын шаардлага хангасан өвсийг хүлээн авч нөөц бүрдүүлэхийг Тамгын газрын дарга Б.Оюунчимэг, Хөдөө аж ахуйн тасгийн дарга Ш.Бямба нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ